



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 01 сарын 06 өдөр

Дугаар А/02

Мандалговь

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 45 дугаар зүйлийн 45.2, 45.6 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.2, 46.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны төсөв баталсан тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.1 Хот тохижуулах газрын албан хэрэгцээнд хог тээврийн автомашин нийлүүлэх, 3.2 Хот тохижуулах газрын албан хэрэгцээнд бункер өргөгч машин нийлүүлэх, 3.3 Хот тохижуулах газрын албан хэрэгцээнд 5 бункер нийлүүлэх, 3.9 Хот тохижуулах газрын албан хэрэгцээнд ковш машин нийлүүлэх, 2 дугаар хавсралтын 1.6 Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын автомашины парк засварын ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Сайнцагаан сумын Засаг дарга (Р.Мөнхтогтох)-д шилжүүлсүгэй.

Хоёр. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулж, гүйцэтгэлээр санхүүжүүлэх, Засаг даргад эрх шилжүүлсэн арга хэмжээний явцын мэдээллийг сар бүрийн 2-ны дотор Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст тайлагнаж ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга (Р.Мөнхтогтох)-д даалгасугай

Гурав. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир)-д, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060004